



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/327

Чингис хот

Сургалтын зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2021 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Зөгийн үүр" арга хэмжээний хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмэн эмчилгээний зохицуулгын хорооны гишүүдийг хамруулан онолын мэдлэгийг бататгах зорилгоор "Бодисын солилцооны алдагдал төвийн зохицуулгын эмгэг жам", "Анагаах ухааны салбарын эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулахад 800,000 (найман зуун мянга)-н төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Г.Лхагавхатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011715